

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН
ЧИНБАТЫН ЦОЛМОНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. “САЙД, ДЭД САЙД, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БОЛОН ЯАМНЫ ХЭМЖЭЭНД АЛБАН БОЛОН АЖЛЫН АЙЛЧЛАЛ, ГАДААД ТОМИЛОЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА.”							
1.	Арга хэмжээ 1.1 Яамны албан хаагчдын гадаад албан томилолтоор ажиллахад дэмжлэг үзүүлнэ.	Зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0	69	20	Тайлант хугацаанд тус яамны нийт 35 албан хаагч 10 улсад зохион байгуулагдсан 20 арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлж ажиллав. Үүнд: 1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Сансрын асуудал эрхэлсэн алба /UNOOSA/ болон НҮБ-ын Их сургуулиас хамтран Япон Улсын Токио хотноо зохион байгуулсан “Ази Номхон далайн орнуудын Сансрын хуулийн зөвлөгөөн”-д 1 алба хаагч; 2.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралын Америкийн Нэгдсэн Улсад хийх ажлын айлчлалын бүрэлдэхүүнд 7 албан хаагч; 3.Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагаас зохион байгуулсан “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн төслийн төлөвлөлтийн чадавх бэхжүүлэх” сургалтад 1 албан хаагч; 4.БНКУ-ын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Дижитал Алматы 2024”-д 3 албан хаагч; 5.“Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024” арга хэмжээнд 3 албан хаагч; 6.Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагаас зохион байгуулсан “Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг чадавхжуулах” сэдэвт сургалтад 2 албан хаагч;	01-09	100

				7.Оросын Холбооны Улсын Цахим хөгжил, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн яамнаас зохион байгуулсан “Евроазийн мэдээллийн технологийн анхдугаар форум”-д 3 албан хаагч; 8.Дэлхийн Банкнаас зохион байгуулсан “Дэлхийн цахим чуулган”-д 1 албан хаагч; 9.Карнеги Меллон Их сургуулийн Технологийн бодлогын удирдлагын төвөөс зохион байгуулсан “Цахим худалдаа: Дижитал эдийн засгийн олон улсын худалдааны дүрэм, экосистем ба дижитал өөрчлөлт” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 10.АНДЦХБ-аас зохион байгуулсан “Утасгүй холбооны багийн 32 дугаар уулзалт”-д 1 албан хаагч; 11.БНСУ-ын Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан “Ардчиллын төлөөх Дээд түвшний уулзалт”-д 1 албан хаагч; 12.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яамнаас зохион байгуулсан “Цахим худалдаа” сэдэвт сургалтад 2 албан хаагч; 13. Бүгд Найрамдах Казакстан Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкттай хамтран тус улсын Астана хотноо Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан “Цахим худалдааны хоёрдугаар форум”, “Бүс нутгийн худалдааны ажлын хэсгийн зургаадугаар уулзалт”, “Цахим хөгжлийн үзэсгэлэн болон туршлага судлах арга хэмжээ”, “Цахим стратегийн удирдах хорооны хоёрдугаар уулзалт”-д 1 албан хаагч; 14. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас зохион байгуулсан “Олон улсын хуралд бэлтгэх нь” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 15. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын “Хөгжлийн төлөвлөгөөний хорооны уулзалт”-д 2 албан хаагч; 16. Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагаас зохион байгуулсан “3-р бүсийн орнуудад зориулсан Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн семинар”-т 1 албан хаагч;		
--	--	--	--	--	--	--

					17. Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагаас зохион байгуулсан “Дэлхийн радио холбооны их хурал (WRC27)-д бэлтгэх Ази, Номхон Далайн бүсийн нэгдүгээр бэлтгэл хурал”-д 1 албан хаагч; 18. АНУ-ын Төрийн департаментас зохион байгуулсан “AI Connect II” хөтөлбөрийн Азийн бүсийн сургалт, хэлэлцүүлэгт 1 албан хаагч; 19. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллага болон БНСУ-ын Мэдээллийн нийгмийн агентлагтай хамтран зохион байгуулсан чадавхжуулах хөтөлбөрт 1 албан хаагч; 20. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан “Кибер халдлагаас хамгаалах дадлага” сэдэвт сургалтад 1 албан хаагч тус тус оролцсон. 21. Гадаад харилцааны сайдын Америкийн Нэгдсэн Улсад хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд 2024 оны 07 дугаар сарын 19-нөөс 26-ны өдрүүдэд, 1 албан хаагч, 22. “Дэлхийн сансрын бизнесийн долоо хоног арга хэмжээ” болон Монгол Улсын “Үндэсний хиймэл дагуул” хөтөлбөрийн хүрээнд холбогдох уулзалтад оролцохоор 2024 оны 09 дүгээр сарын 15-наас 21-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Франц Улсад 1 албан хаагч албан томилолтоор ажилласан.		
Зорилт 2. “ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, ГАДААД УЛСЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРИЙН БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАНА.”							
2.	Арга хэмжээ 2.1. Олон улсын байгууллага, гадаад улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулах, Гадаад харилцааны эрхэлсэн төрийн захиргааны төв	Бэлтгэл хангасан ажлын хэрэгжилтээр Тийм-1, Үгүй-0	3	1	1.Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Арабын Нэгдсэн Эмират Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Хиймэл оюун ухааны газар хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах ажлыг зохион байгуулж, байгуулсан санамж бичгийн хуулбарыг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэв. 2.Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яам хооронд Мэдээлэл, харилцаа холбооны салбарт хамтран ажиллах	01-09	100

	байгууллагад бүртгүүлнэ.			тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах ажлыг зохион байгуулж, байгуулсан санамж бичгийн хуулбарыг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэв. 3.Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Колумби Улсын Мэдээлэл, харилцаа холбооны технологийн яам хоорондын цахим засаглалын чиглэлээр хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах ажлыг зохион байгуулж, байгуулсан санамж бичгийн хуулбарыг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэв. 4. Монгол Улс болон Оросын Холбооны Улсын харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн байгууллага хооронд хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалтын гэрээ, хэлэлцээ хийх ээлжит уулзалт 2024 оны 04 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Тус уулзалтын үеэр радио давтамжийн 29.7-470 МГц, 450 МГц, 150 МГц, 700 МГц зурваст газрын хөдөлгөөнт болон 29.7-39.5 МГц зурваст газрын хөдөлгөөнт бус үйлчилгээний зохицуулалтын асуудлуудыг хэлэлцэн нийт 4 гэрээг шинээр байгуулахаар тогтож, дипломат шугамаар талууд гарын үсэг зурахаар тохиролцов. 5. Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн байгууллага хооронд хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалтын гэрээ, хэлэлцээ хийх ээлжит уулзалт 2024 оны 05 дугаар сарын 21-23-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Тус уулзалтын үеэр радио давтамжийн 1920-1965/2110-2155 МГц зурваст газрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээний зохицуулалтын гэрээг шинээр байгуулж, байгуулсан		
--	-----------------------------	--	--	---	--	--

					гэрээний хуулбарыг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэв.		
Зорилт 3. “МОНГОЛ УЛСЫН ГИШҮҮНЧЛЭЛ БҮХИЙ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА.”							
3.	Арга хэмжээ 3.1. Гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалт, арга хэмжээнд оролцуулна.	Оролцсон арга хэмжээний тоо	29	15	Тайлант хугацаанд тус яамны нийт 7 албан хаагч 10 улсад зохион байгуулагдсан 6 арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлж ажиллав. Үүнд: 1. АНДЦХБ-аас зохион байгуулсан “Утасгүй холбооны багийн 32 дугаар уулзалт”-д 1 албан хаагч; 2. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас зохион байгуулсан “Олон улсын хуралд бэлтгэх нь” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 3. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын “Хөгжлийн төлөвлөгөөний хорооны уулзалт”-д 2 албан хаагч; 4. Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагаас зохион байгуулсан “3-р бүсийн орнуудад зориулсан Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн семинар”-т 1 албан хаагч; 5. Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагаас зохион байгуулсан “Дэлхийн радио холбооны их хурал (WRC27)-д бэлтгэх Ази, Номхон Далайн бүсийн нэгдүгээр бэлтгэл хурал”-д 1 албан хаагч; 6. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллага болон БНСУ-ын Мэдээллийн нийгмийн агентлагтай хамтран зохион байгуулсан чадавхжуулах хөтөлбөрт 1 албан хаагч тус тус оролцов.	01-09	100
Зорилт 4. “САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ УРИЛГААР МОНГОЛ УЛСАД ИРЭХ ГАДААДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АЙЛЧЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛНА.”							
4.	Арга хэмжээ 4.1. Яамны урилгаар Монгол Улсад ирэх гадаадын төлөөлөгчдийн айлчлалын бэлтгэл ажлыг хангана.	Зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0	20	2	1. Цахим хөгжил, харилцааны холбооны сайд Н.Учралын урилгаар Бүгд Найрамдах Казахстан Улсын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн тэргүүн дэд сайд Тулеушин Каныш тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад 2024 оны 4 дүгээр сарын 29-нөөс 5 дугаар сарын 02-ны хооронд ажлын айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн цахим	01-09	100

					үйлчилгээний зохицуулалтын газар болон Казахстаны Үндэсний мэдээллийн технологи ХК хооронд “Харилцаа холбооны технологийн салбарт хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулав. Айлчлалын үеэр хоёр орны хооронд цахим салбарын туршлага солилцох, хамтын ажиллагааны хамтарсан төлөвлөгөө хэрэгжүүлж ажиллах асуудлаар санал солилцох өргөтгөсөн уулзалт, хувийн хэвшлийн байгууллагууд хооронд хэлхээ холбоо тогтоох, хамтын ажиллагааг идэвхжүүлэх “B2B” уулзалт, төрийн үйлчилгээний “Хур”, “Дан” систем болон нэг цэгийн үйлчилгээний төвүүдтэй танилцах зэрэг арга хэмжээг зохион байгуулав. 2. “Хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалтын Монгол Улс болон Оросын Холбооны Улсын харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоорондын хоёр талт уулзалт, хэлэлцээ”-г 2024 оны 04 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Уулзалт хэлэлцээний дүнд 2 орны хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн харилцан нөлөөллөөс сэргийлэх, байгалийн хязгаарлагдмал нөөц болох радио давтамжийг газрын сүлжээнд үр ашигтай ашиглалтыг зохицуулах чиглэлээр газрын хөдөлгөөнт болон хөдөлгөөнт бус үйлчилгээний 4 хэлэлцээрийг батлахаар Талууд тохиролцоонд хүрч, Хэлэлцээний хураангуй тэмдэглэлд хоёр талын Төлөөлөгчдийн тэргүүн нар гарын үсэг зурж баталгаажуулав. 4 хэлэлцээрийг дипломат шугамаар солилцож, гарын үсэг зурахаар тохиролцов. 3. “Хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалтын Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоорондын хоёр талт хуралдаан”-ыг 2024 оны 05 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд ХХЗХ-той хамтран зохион байгуулав. Зохион байгуулалтын хүрээнд тус хуралдааны үеэр монгол-хятад хэлээр орчуулга хийх орчуулагчийг сонгон шалгаруулж, сонгогдсон орчуулагчтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулж,		
--	--	--	--	--	---	--	--

					хуралдааны үеэр байгуулах нэг гэрээний төслийг Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газраар хянуулж, зөвшөөрөл авч ажиллав.		
Зорилт 5. “ГАДААД УЛС ОРНУУДАД ЗОХИОН БАЙГУУЛАХ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЗЭСГЭЛЭН, ЭКСПОД ТӨРИЙН БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ОРОЛЦУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА.”							
5.	Арга хэмжээ 5.1. Гадаад улс орнуудад зохион байгуулах мэдээлэл, харилцаа холбооны салбарын үзэсгэлэн, экспод төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулах бэлтгэл ажлыг хангана.	Арга хэмжээний тоо	2	1	Испанийн Хаант Улсын Барселон хотноо 2024 оны 02 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд Дэлхийн үүрэн холбооны ассоциациас зохион байгуулсан “Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024”-т Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг тэргүүтэй харилцаа холбоо, программ хангамжийн салбарын төлөөлөгчид Монгол Улсын цахим шилжилт, технологийн хөгжил, хөрөнгө оруулалтын боломжийг олон улсад сурталчлан таниулах зорилгоор анх удаа үзэсгэлэнгийн талбай байгуулж амжилттай оролцов. Тус арга хэмжээнд Монгол Улсаас төр хувийн хэвшлийн 80 гаруй төлөөлөгчид оролцох бэлтгэл ажлыг хангаж ажилласан.	01-09	100
Зорилт 6. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАНА.”							
1.	Арга хэмжээ 6.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу албан бичиг боловсруулна, шийдвэрлэнэ.	Боловсруулсан, шийдвэрлэсэн албан бичгийн тоо	88, 47	30, 20	Тайлант хугацаанд ирсэн 15 албан бичгийг шийдвэрлэж, монгол хэлээр 35, англи хэл дээр 34 албан бичгийг боловсруулав.	01-09	100
2.	Арга хэмжээ 6.2. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг архивд хүлээлгэн өгнө.	Архивд өгсөн баримт бичгийн тоо	-	4	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар батлагдсан Гадаад орнуудтай байгуулсан байгууллага хоорондын гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн 2022, 2023 оны баримт бичиг, Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын гадаад улсын элчин сайд, олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэл нийт 3 боть хүлээлгэн өгөв.	01-09	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Гаднын байгууллага болон дотооддоо зохион байгуулсан сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан тоо	2	1	Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтын хөтөлбөрийн дагуу "Төрийн албаны шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн, Төрийн албаны цалин хөлс, нийгмийн баталгаа, Төрийн албаны ёс зүйн дэд хорооны журмыг хэрэгжүүлэх тухай, Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох, Байгууллага хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага сэдэвт сургалтад тус тус цахимаар хамрагдав.	01-09	100
2.	Арга хэмжээ 2 Яамнаас зохион байгуулах мэдээллийн цаг, сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан тоо	-	1	2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр "Рациональ сэтгэлгээ буюу бодож сурах нь" цуврал сургалтад танхимаар хамрагдав. Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ур чадварын түвшин, ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшил, тасралтгүй мэргэшүүлэх чиглэлийн цахим сургалтад тухай бүр цахимаар хамрагдсан.	01-09	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГХАХ-ийн мэргэжилтэн
(Албан тушаал)

Ч.Цолмон / *Ч.Цолмон* /
(Нэр, гарын үсэг)

(Огноо)